



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/404

Улаанбаатар хот

Хяналтын хуудас батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6, 5.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 30 дугаар зүйлийн 30.1.4, Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-ын 15.3, 16.1, 16.3, Засгийн газрын 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм"-ийн 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгах хяналтын хуудас"-ыг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ батлагдсан хяналтын хуудсыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (бригадын генерал Ж.Чүлтэмсүрэн)-д даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

000004231

H:/2023/3,4/tushaal-2023-3,4.doc

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
11/404 дугаар тушаалын хавсралт



ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Хяналтыг хэрэгжүүлэх салбар, нэгж:		
Шалгуулагч этгээдийн нэр:		
Регистрийн дугаар:		
Объектын нэр, хаяг, солбицол:		
Байгуулагдсан огноо:		
Үйл ажиллагааны чиглэл, ажилчдын тоо:		
Дарга, захирал /иргэн, эрхлэгч/-ын нэр, холбоо барих утасны дугаар:		
Хяналт шалгалт хийсэн огноо:	Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн огноо:	Гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн огноо:
Шаардлага хангасан асуултын тоо:	/...../...../...../	/...../...../...../
Шаардлага хангаагүй нийт оноо:	/...../...../...../	/...../...../...../
Хууль сахин мөрдөлтийн хувь:	/...../...../...../	/...../...../...../
Эрсдэл үүсэх магадлалын хувь:	/...../...../...../	/...../...../...../
Эрсдэл үүсэх магадлал:	/их, дунд, бага/	/их, дунд, бага/

2. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ:

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Батлагдсан оноо		Авсан оноо	Гүйцэтгэлийн хяналт шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
1		2	3	4	5	6
1		Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийлгэсэн эсэх?	0	5		
2	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.6, 9 дүгээр зүйлийн 9.1.3, 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.2.5 дахь заалт	Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн эсэх?	0	5		
3		Гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн арга хэмжээг хэрэгжүүлсэн эсэх?	0	5		
4		Гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн бус арга хэмжээг хэрэгжүүлсэн эсэх?	0	5		

5	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын 3 дугаар хавсралт "Байгууллага аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар"-ын 1.12 дахь хэсэгт	Байгууллагын хөгжлийн бодлого төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцож тусгасан эсэх?	0	5		
6	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 51.2, 51.4 дэх хэсэгт	Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээгээр төлөвлөж, зарцуулсан эсэх?	0	5		
7	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 10 дугаар зүйлийн 10.3, 10.4, 10.7, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.2.1 дэх заалт	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй эсэх?	0	5		
8	Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын 3 дугаар хавсралт "Байгууллага аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар"-ын 1.3, 1.10 дахь хэсэгт	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах байгууллагын удирдлагын шийдвэрээр ажлын хэсэг байгуулсан эсэх?	0	5		
9	Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын 3 дугаар хавсралт "Байгууллага аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар"-ын 3.6.1 дэх заалт	Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хавсралтуудыг бүрдүүлсэн эсэх?	0	5		
10	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2 дахь заалт, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/388 дугаар тушаалын 3 дугаар хавсралт "Байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загвар"	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулахад чиглэгдсэн эсэх?	0	5		
11	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.1 дэх заалт, Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын 3 дугаар хавсралт "Байгууллага аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө"	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгосон эсэх?	0	5		

	боловсруулах заавар"-ын 1.9, 4.2 дахь хэсэгт					
12	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.3, 10.3.5, 10.3.6 дахь заалт, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/383 дугаар тушаал "Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах үзлэг, шалгалт явуулах, үнэлэх журам"-ын 2 дугаар хавсралтын Хуулийн этгээдийн бэлэн байдлыг дүгнэх үзүүлэлтийн хүснэгтийн 1а, б, г, 2 а, б, 3, 5 а, б, в, 6 г, 7, 8 а, б, 9 б, 10, 12 дугаар зүйл.	Хуулийн этгээд нь болзошгүй гамшгийн үед гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангасан эсэх?	0	5		
13	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт	Болзошгүй гамшгийн үед түр цугларах аюулгүйн талбайтай эсэх?	0	5		
14	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.6 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам"-ын 2 дугаар хавсралтын 1.4, 5.3.2, 5.3.3 дахь заалт	Болзошгүй гамшгийн үед өөрийн байгууллагад байгаа материал хэрэгслийг гаргаж зарцуулах нөөцтэй эсэх?	0	5		
15	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.1 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн аюулыг зарлан мэдээллийн дохио дамжуулах журам"-ын 1.4, 5.2 дахь хэсэгт	Гамшгийн тухай зарлан мэдээллийг хүлээн авмагц мөрдөх журам, батлагдсан төлөвлөгөөтэй эсэх?	0	5		
16	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.2, 10.3.7, 13 дугаар зүйлийн 13.3, 13.4, 13.5, 34 дүгээр зүйлийн 34.2.4 дэх заалт	Гамшгаас хамгаалах сургалтыг тогтоосон хугацаанд зохион байгуулсан эсэх?	0	5		
17	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.8 дахь заалт, Зөрчлийн тухай хуулийн 5.13.5 дахь заалт	Өөрийн байгууллагын хэрэгцээнд ашиглах барилга байгууламж, хоргодох байрыг төхөөрөмжилсөн, шаардлагатай тохиолдолд хүн амд ашиглуулах, зориулалтыг дур мэдэн өөрчлөхгүй байх хуулиар хүлээсэн үүргийг судалсан эсэх?	0	5		
18	Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолоор	Болзошгүй гамшгийн үед дайчлагдан ажиллах танай	0	5		

	батлагдсан "Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам"-ын 1 дүгээр хавсралтын 4.2.4 дэх заалт	байгууллагын ажилтны эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах арга хэмжээг хангасан эсэх?				
19	Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам"-ын 1 дүгээр хавсралтын 1.2, 3.3, 3.4, 4.5 дахь хэсэгт	Гамшгийн үед дайчлан ажиллах танай байгууллагын бүх төрлийн тээврийн хэрэгсэл, өөрөө явагч машин механизм даатгалд хамрагдсан эсэх?	0	5		
20	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.2 дахь заалт, Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын 3 дугаар хавсралт "Байгууллага аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар"-ын 3.6.1.5 дахь заалт, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/274 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, ажиллах журам"-ын 2.4 дэх хэсэг	Ажлын тусгай горимд шилжин ажиллах төлөвлөгөөтэй эсэх?	0	5		
Нийт оноо			0	100		

Шаардлага хангаагүй нийт оноо:

>=50% Их эрсдэлтэй
 [30%-49%] Дунд эрсдэлтэй
 <=29% Бага эрсдэлтэй

3. БАТАЛГААЖУУЛАЛТ:

Улсын байцаагчийн албан тушаал, нэр, гарын үсэг, тэмдэг	Шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг	Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн: шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг
/ албан тушаал /	/ албан тушаал /	/ албан тушаал /
/ овог, нэр /	/ овог, нэр /	/ овог, нэр /
/ гарын үсэг, тэмдэг /	/ гарын үсэг, тэмдэг /	/ гарын үсэг, тэмдэг /

ТАЙЛБАР:

.....

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР